

Монгол болон Японы боловсролын харьцуулсан

судалгааны анхны зарим дүгнэлт

Доктор (Ph.D) С. Төмөр-Очир

Өнөөгийн тэргүүний хөгжилтэй улс орны туршлагаас харахад өөрийн иргэдийн боловсрол, хүмүүжилд тэргүүн зэргийн анхаарал тавьж хөгжүүлж байж ийм амжилтад хүрчээ.

Дэлхий нийтийн боловсрол судлаачид боловсролын 5 үндсэн загвар байна. Энэ нь АНУ, Англи, Франц, Герман, Япон улсын боловсролын систем юм. Дэлхийн аль ч орны боловсролын систем эдгээр боловсролын системийн төсөөтэй хувилбар байдаг гэж үзэж байна.

Аль ч орны боловсролын загварыг судалсан түүнийг шууд хуулбарлалгүй тухайн орныхоо түүхэн болон эдийн засаг, улс төр, хүн ардын соёл, боловсрол, ёс зүйн өвөрмөц онцлогийг заавал тооцож үзэх ёстой юм.

Монгол Японы боловсролын салбарыг харьцуулан судлах явцад анхны хэд хэдэн дүгнэлтийг хийж болохоор байна.

Хоёр орны боловсролын систем нь бүтэц зохион байгуулалтын болон хэрэгжүүлж байгаа сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийн загвар нь дэлхийн ерөнхий стандарттай дүйцэж байна. Харин хичээлийн хөтөлбөрийн агуулга, бүтэц, хэрэгжүүлж байгаа арга барил нь нилээд ялгаатай байна. Иймд Японы боловсролын сайн талуудыг сонгон авч Монголд нутагшуулах явдал чухал гэж үзэж байна. Ийм сайн талууд нь:

1. Япон орны хөгжил дэвшлийн үндэс нь япон ээжид байгаа юм байна. Япон эмэгтэй хүн хүүхэд гаргамагц ажлаасаа гарч зөвхөн хүүхдээ л хүмүүжүүлдэг байна. Ингэснээр маш сайн хүмүүжил, боловсролтой япон иргэн төлөвшдөг байна

Японы бага сургуульд шинжлэх ухааны мэдлэг олгохоосоо илүү эцэг эх, багш нар ер нь хүнийг яаж хүндлэх ёстой японы уламжлалт зан заншлыг ойлгуулж хэвшүүлж дадал болгодог байна.

2. Японд Япон хүний стандарт гэж байдгийн адил Монгол хүний боловсролын стандартыг бий болгох нь чухал байна.

3. Японы сургалтын системийн сайн тал нь онолын мэдлэгийн зэрэгцээ практик чадвар сайн суулгаж, сурагчдаар гараар нь маш сайн ажиллуулж мэдлэг, чадвар, дадал, хандлагыг жигд тэгш олгож чадаж байна. Цаашид сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийн бүтэц, дэс дараа, агуулга түүнийг хэрэгжүүлэх арга барилыг харьцуулан судалж дүгнэлт гаргах шаардлагатай гэж үзэж байна.